

## ГАДНЫ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭД ШУГАМ ХООЛОЙ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР УГСРАЛТЫН АЖИЛ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. “ДДС” ТӨХК-ийн алба, хэлтэс, нэгж, ажилтнуудаас өөр бусад байгууллага, иргэдэд дулааны шугам хоолой, тоног төхөөрөмжийн угсралт, засварын ажил хийж гүйцэтгэх ажлыг журамлах, эдгээр ажлыг гүйцэтгэхэд холбогдох дүрэм, журмыг мөрдүүлж, ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, ил тод байдлыг хангуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журам нь “ДДС” ТӨХК -ийн тусгай зөвшөөрөл авсан: а/ зуухны угсралт, засвар; б/ даралтат савны угсралт, засвар; в/ шугам хоолойн угсралт, засвар; г/ зуух, даралтат сав, шугам хоолойн хийц хэсгүүдийн үйлдвэрлэлт; д/ 0,7-40 кгх/см<sup>2</sup> даралттай шугам хоолойн засвар угсралт, туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ; е/ Мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил, Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт, Дулааны гол /магистраль/ шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт; ё/ Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн усны тоолуур, манометр, дулааны тоолуурыг засварлах, суурилуулах, худалдах; зэрэг ажилд хамаарна.

1.3. Энэхүү журмыг “ДДС” ТӨХК -ийн ИТА, албан хаагч, слесарь, машинистууд болон бусад бүх ажилтнууд дагаж мөрдөнө.

### Хоёр. Ажил гүйцэтгэх нөхцөл

2.1. “ДДС” ТӨХК -ийн алба, хэлтэс, нэгж, ажилтнуудаас материал, техник, хүний нөөцийг үр дүнтэй ашиглахын тулд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр компанийн захиргаатай харилцан тохиролцож гадны байгууллага, иргэдэд шугам хоолой, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, туршилт тохируулгын ажил, үзлэг үйлчилгээ, гэмтэл устгах зэрэг ажил хийж өгч болно.

2.2. Гадны байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсны үндсэн дээр ажил гүйцэтгэх ба ингэхдээ ажлын зураг, төсөв нь батлагдсан, зохих газруудаас /аймгийн Мэргэжлийн хяналтын алба, Холбооны газар, Ус суваг, ДСЦТС ХК, ДДС ХК г.м./ зөвшөөрөл авсан байвал зохино. Жижиг засвар буюу гэмтэл устгах ажлын хөлсийг харилцан тохиролцох буюу эсвэл мөрдөж байгаа тариф үнэлгээг үндэслэн гүйцэтгэж болно.

2.3. Байгууллага хоорондын гэрээгээр ажиллан “ДДС” ТӨХК -д ашиг оруулсан ажилтнуудад “ДДС” ТӨХК-ийн ажилтнуудад үйл ажиллагааны бус орлогоос шагнал урамшуулал олгох журам”-ын дагуу урамшуулал олгоно.

2.4. “ДДС” ТӨХК-ийн тусгай зөвшөөрлийг ашиглан тус байгууллагын ажилтнууд нь амралт чөлөөт цагаараа буюу ажлын бус цагаар хувиараа засвар үйлчилгээний ажил гүйцэтгэх тохиолдолд “ДДС” ТӨХК -тай бичгээр тохиролцон, тухайн ажлын ажиллах хүчний зардлын 10-30 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг “ДДС” ТӨХК -ийн дансанд шилжүүлнэ.

2.5. Хувиараа ажил гүйцэтгэх үед байгууллагын бололцоог харгалзан машин механизмын туслалцаа авах тохиолдолд хэрэглэсэн механизмын хөлсийг тарифын дагуу “ДДС” ТӨХК -д төлөх ба ажил гүйцэтгэх явцад машин механизмд гэмтэл гарсан тохиолдолд түрээслэгч нь өөрөө бүрэн хариуцаж засвар үйлчилгээг хийн компаний хохирлыг барагдуулна.

**Гурав. Ажил гүйцэтгэхэд тавигдах шаардлага**

3.1. Гадны байгууллагад ажил гүйцэтгэх ажилтнууд нь мэргэжлийн зохих дадлага туршлагатай, урьд өмнө ижил төрлийн ажил гүйцэтгэж байсан ажилтан байвал зохино. Гагнуурчид нь тухайн даралт, температуртай шугам хоолой, даралтат сав болон хийц, эд ангийг гагнах эрхтэй байна.

3.2. Ажил гүйцэтгэх үед Монгол улсын нутаг дэвсгэрт мөрдөж байгаа хууль тогтоомж болон техникийн ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно. Үүнд:

- Эрчим хүчний тухай хууль;
- Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм;
- Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм;
- Уур халуун усны шугам хоолойг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм;
- Даралтат савыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм;
- Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэм;
- Цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрэм;
- Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм;
- БнБД 3.05.03-95 Дулааны сүлжээ г.м

3.3. Зураг төсөвт заагдсан ажлуудыг технологийн дагуу бүрэн гүйцэд хийх ба өөрчлөлт хийх шаардлагатай бол зохиогчийн зөвшөөрлийг авч өөрчилсөн зургийг “ДДС” ТӨХК -аар хянуулсан байна.

3.4. Ажилтнууд нь батлагдсан зураг төсөв, техникийн нөхцлийн шаардлагуудыг зөрчихийг хориглоно.

**Дөрөв. Гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэж өгөх**

4.1. Шинээр баригдах барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэсэн үед Засгийн газрын 2012.12.01-ний 151-р тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах дүрэм”-ийн дагуу баримт бичгүүдийг бүрдүүлж зохих шатны комисст хүлээлгэн өгнө.

4.2. Шугам хоолой тоноглолд хийвэл зохих шахалт, туршилтуудыг захиалагчийн болон "ДДС"ТӨХК -ийн төлөөлөгчийг байлцуулан гүйцэтгэх бөгөөд тухай бүрд нь акт үйлдэж баталгаажуулна.

4.3. Шугам хоолой солих буюу засварлах ажил хийсэн тохиолдолд нягтын шахалтыг заавал хийх бөгөөд шахалт хийсэн актыг хөтөлсөн байна.

4.4. Гудамж талбайн тохижилт, байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээг захиалагчтай байгуулсан гэрээнд тодотгон тусгаж нөхөн сэргээлт тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн байх ёстой.

**Тав. Хариуцлага**

5.1. Гадны байгууллагад ажил гүйцэтгэхдээ хууль тогтоомж, дүрэм журам болон батлагдсан зураг төсөв, техникийн нөхцөл зөрчсөн бол хууль тогтоомжийн дагуу ажил гүйцэтгэгч нь зохих хариуцлага хүлээнэ.

5.2. Ажлыг чанар муутай хийж компанийн нэр хүндийг унагасан, шахалтын болон бусад холбогдох акт бичиг баримт дутуу үйлдсэн, туршилт тохируулга, зүгшрүүлгийн ажил хийгээгүй буюу дутуу хийсэн бол компанийн ХДЖ-ийн дагуу ажил гүйцэтгэгч нь зохих хариуцлага хүлээнэ.

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_